



“ЦЭСБ-Аудит”
ХХК

“ЦЭСБ АУДИТ” ХХК АУДИТЫН ТАЙЛАН

“ДАРХАН НЭХИЙ” ХК-ИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

/2025 оны 12 сарын 31-нээр дуусгавар болсон /

ДАА-СТА-2026/033



“ЦЭСБ АУДИТ” ХХК
Нягтлан бодох бүртгэл хяналтын
итгэмжлэгдсэн хөндлөнгийн байгууллага

Хаяг: Дархан-Уул аймаг, Дархан сум, 10-р баг, 5-р
хороо, 380 айл, 2 давхар 65, 66 тоот
Утас: 9511-2689, 8927-5858

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“ДАРХАН НЭХИЙ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

Бид 2025 оны 12 дүгээр сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуй багтаасан нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодрууллагаас бүрдсэн “Дархан нэхий” ХК-ийн санхүүгийн тайланд аудитыг хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр “Дархан нэхий” ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх нэгтгэсэн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны орлого, зардал, үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн баталсан жухам, заавар, аргачлалын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Энэ стандартын дагуу бидний хүлээх хариуцлагыг энэхүү тайлангийн санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу үйлчлүүлэгчээс хараат бус байх, эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагуудыг “МНБ-ын ёс зүйн дүрэм” –г мөрдөж ажилласан.

Аудитын гол асуудлууд

Бидний гаргасан тайланд анхаарал хандуулахуйц аудитын гол асуудал байхгүй гэж тодорхойлж байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлийн хувьд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл нь жилийн тайланд орсон мэдээлээс бүрддэг боловч түүнд санхүүгийн тайлан болон бидний аудиторын тайлан ордоггүй. Санхүүгийн тайланд гаргасан бидний дүгнэлт бусад мэдээллийг хамардаггүй бөгөөд бид бусад мэдээллийн талаар аливаа баталгаажилтын дүгнэлт гаргахгүй.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН **(үргэлжлэл)**

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой бид бусад мэдээллийг унших үүрэгтэй учраас уг мэдээлэл нь санхүүгийн тайлантай материаллаг байдлын хувьд нийцэж байгаа эсэхийг авч үзнэ. Хэрэв бид хийсэн ажилдаа үндэслэн бусад мэдээлэл материаллаг буруу тайлагнал байна гэж дүгнэсэн бол энэ байдлыг тайландаа тусгах ёстой. Аудитын явцад бид энэ талаар тайлагнах шаардлага үүсээгүй болно.

Санхүүгийн тайлангийн талаар удирдлага болон засаглах удирдлагын хүлээх хариуцлага

Удирдлага нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэг хүлээхээс гадна залилан эсвэл алдаанаас үүдэн материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд зайлшгүй чухал гэж тодорхойлсон дотоод хяналтуудыг тодорхойлно.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага компанийн үйл ажиллагааг төлбөрийн чадваргүй болох эсвэл үйл ажиллагааг зогсоох, ингэхээс өөр сонголтгүй байхаас бусад тохиолдолд удирдлага санхүүгийн тайлангаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх хариуцлагыг хүлээх ба тасралтгүй байдалтай холбоотой асуудлууд болон нягтлан бодох бүртгэлд ашигласан тасралтгүй байдлын суурийн талаар нэмэлт тодруулга хийнэ.

Санхүүгийн тайлангийн аудит Аудиторын хүлээх хариуцлага

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй бэлтгэгдсэн эсэх талаар хамгийн боломжит баталгааг олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагнал бүрийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгааг өгөхгүй юм. Залилан эсвэл алдаанаас шалтгаалан буруу тайлагнал үүсэж болох ба дангаараа эсвэл нийтдээ материаллаг гэж үзсэн бол санхүүгийн тайланд тулгуурлан хэрэглэгчийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх боломжтой юм.

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл иргэх хандлагыг баримтлан мэргэжлийн шийдэл гаргаж ажилласан. Мөн бид:

- Санхүүгийн тайланд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагнал байх эрсдэлийг тодорхойлж үнэлсэн. Тэдгээр эрсдэлүүдэд хариу аудитын горимуудыг тодорхойлж хэрэгжүүлсэн. Мөн дүгнэлтийн үндэслэл болох аудитын хангалттай нотолгоог олж авсан. Гэхдээ алдаанаас бус компанийн үгсэн хуйвалдсан үйл ажиллагаа, хуурамчаар үйлдэх, санаатай орхигдуулах, дотоод хяналтыг үл хэрэгсэх эсвэл гуйвуулах зэрэг залилангаас шалтгаалсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэлтэй.
- Аудитын зохистой горимыг боловсруулахын тулд компанийн дотоод хяналтын тогтолцооны талаар ойлголт олж авсан, гэхдээ дотоод хяналтын үр дүнтэй байдалд дүгнэлт өгөхийг зориогүй.
- Компанийн ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, удирдлагын хийсэн тооцоолол болон тодруулгын зохистой байдлыг үнэлсэн.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

- Хэрэв компанийн тасралтгүй байх чадавхид материаллаг тодорхойгүй байдал байна гэж үзвэл бид санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгын хэсэгт бид анхаарлаа хандуулах болно. Хэрэв энэ талаар холбогдох тодруулгад хангалттай дурдаагүй байдал бид аудитын дүгнэлтээ өөрчлөх болно. Бидний өгөх аудитын дүгнэлт нь аудиторын тайланг огноолох өдөр хүртэлх аудитын нотолгоонд суурилна. Иймд компанийн тасралтгүй байх чадварт нөлөөлөх нөхцөл байдал ирээдүйд үүсэж болох юм.
- Санхүүгийн тайлангийн бүтэц, агуулга, толилуулга болон тодруулгыг бид бүхэлд нь шалгаж санхүүгийн тайлан нь ажил гүйлгээ ба үйл явдлыг үнэн зөв харуулсан эсэхийг үнэлсэн.

Бид засаглах удирдлагатай аудитын цар хүрээ, хугацаа, бусад хамааралтай асуудлуудаас гадна аудитаар илэрсэн томоохон чухал асуудлууд болон аудитын явцад дотоод хяналтаас хэрэгжүүлж буй асуудлуудын талаар харилцсан.

Мөн бид засаглах удирдлагад аудиторын хараат бус байдлын талаар холбогдох ёс зүйн шаардлагуудыг мэдэгдсэн бөгөөд бидний хараат бус байдалд нөлөөлж болохуйц аливаа харилцаа холбоо, түүнээс сэргийлэх арга хэмжээнүүд болон бусад асуудлуудын талаар ярилцсан.

Засаглах удирдлагатай харилцсаны үндсэн дээр бид тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитаар хамгийн чухал гэж авч үзсэн асуудлуудыг тодорхойлж аудитын гол асуудлууд гэж үзсэн. Бид олон нийтэд мэдээлэх нь сөрөг үр дагаврыг авчрах учраас хууль тогтоомжоор хориглосон байдаг асуудлаас бусад аудитын асуудлуудыг аудиторын тайланд харуулсан.

Хэрэглээний хязгаарлалт

Энэхүү тайланг Монгол улсын Компанийн тухай хуулийн 95.1-р зүйлд заасан хуулийн этгээд болох "Дархан нэхий" ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

ЗАХИРАЛ



Ч.ЦЭРЭННАДМИД

АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/2025 оны 12 дугаар сарын 31-ээрхи/

	/төгрөгөөр/	
Үзүүлэлт	1/1/2025	12/31/2025
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгөн ба түүнтэй адилтгах хөрөнгө	4,435,609,473.15	13,188,734,616.58
Дансны авлага	1,093,446,198.90	4,721,419,667.86
Татвар. НДШ-ийн авлага	79,813,037.95	319,583,104.30
Бусад авлага	619,371,758.89	1,070,671,101.00
Бусад санхүүгийн хөрөнгө	9,494,502,800.70	9,588,767,446.20
Бараа материал	15,802,696,257.06	14,293,825,771.04
Урьдчилж төлсөн зардал /тооцоо	3,801,909,897.71	4,272,213,826.70
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө	5,355,775,056.00	-
Эргэлтийн хөрөнгө	40,683,124,480.36	47,455,215,533.68
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	30,508,046,981.55	34,329,440,338.57
Биет бус хөрөнгө	239,363,463.90	112,684,391.83
Урт хугацаат ХО	-	8,697,944,999.08
Дуусаагүй барилга	4,007,919,108.07	4,417,707,541.40
Эргэлтийн бус хөгөнгийн дүн	34,755,329,553.52	47,557,777,270.88
Нийт хөрөнгийн дүн	75,438,454,033.88	95,012,992,804.56
Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	1,009,055,672.39	1,464,550,919.90
Цалингын өглөг	500,837.99	1,527,549.30
Татварын өглөг	5,687,664,877.58	5,621,493,935.63
НДШ-ийн өглөг	9,703,020.67	69,382,041.40
Банкны богино хугацаат зээл	275,637,676.00	2,224,908,024.00
Урьдчилж орсон орлого	857,004,127.09	1,269,157,779.48
Богино хугацаат өр төлбөрийн дүн	7,839,566,211.72	10,651,020,249.71
Урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат зээл	1,370,521,245.00	14,064,684,383.50
Нөөц /өр төлбөр/	44,025,059.49	16,987,591.60
Хойшлогдсон татварын өр	137,544,042.46	-
Урт хугацаат өр төлбөрийн дүн	1,552,090,346.95	14,081,671,975.10
Өр төлбөрийн дүн	9,391,656,558.67	24,732,692,224.81
Хувийн өмч	110,547,900.00	110,547,900.00
Халаасны хувьцаа	16,428,492.00	-
Нэмж төлөгдсөн капитал	(106,648,582.98)	45,962,649.90
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	19,568,028,504.47	19,568,028,504.47
Эздийн өмчийн бусад хэсэг	10,364,088,017.89	17,133,697,418.10
Хуримтлагдсан ашиг	32,485,183,127.83	29,780,037,107.28
Толгой компанийн хувьцаа эзэмшигчдэд ногдох	62,404,770,475.21	66,638,273,579.75
Хяналтын эрхгүй хувь оролцоонд ногдох	3,642,027,000.00	3,642,027,000.00
ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	66,046,797,475.21	70,280,300,579.75
ӨР ТӨЛБӨР БА ЭЗ/ӨМЧИЙН ДҮН	75,438,454,033.88	95,012,992,804.56



АУДИТЛАГДСАН ОРЛОГЫН ТАЙЛАН

/2025 оны 12 дугаар сарын 31-ээрхи/

Үзүүлэлт	/төгрөгөөр/	
	12/31/2024	12/31/2025
Борлуулалтын орлого/цэвэр/	16,542,923,483.95	18,467,919,520.70
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	13,918,143,437.20	10,509,501,432.90
Нийт ашиг	2,624,780,046.75	7,958,418,087.80
Түрээсийн орлого	2,028,838,406.22	2,561,819,065.80
Хүүгийн орлого	1,303,338,744.64	3,979,302,501.90
Ногдол ашгийн орлого	49,450,888.05	40
Эрхийн шимтгэлийн орлого	-	,055,006.60
Бусад орлого	9,832,806,234.78	48
Борлуулалт. Маркетингийн зардал	6,189,707,630.22	,100,100.20
Ерөнхий ба удирдлагын зардал	1,297,693,491.02	5,342,791,087.13
Санхүүгийн зардал	420,481,	820,
	440.86	673,630.90
Бусад зардал	1,026,404,568.94	147,
		471,181.81
Гадаад валютын ханшийн зөрүү олз/ гарз	-	-
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз /гарз/	-	-
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз /гарз/	-	-
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз /гарз/	-	-
Бусад ашиг (алдагдал)	5,563,557.31	185,
		421,049.30
Татвар төлөхийн өмнөх ашиг	6,910,490,746.71	5,372,070,402.25
Орлогын татварын зардал	727,833,647.02	610,821,288.40
Татварын дараах ашиг алдагдал	6,182,657,099.69	4,761,249,113.85
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг алдагдал	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	6,182,657,099.69	4,761,249,113.85
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
Бусад олз (гарз)	-	-
Орлогын нийт дүн	6,182,657,099.69	4,761,249,113.85
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-



АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/2025 оны 12 дугаар сарын 31-ээрхи/

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн	Хяналтын эрхгүй хувь оролцоо	Нийт дүн
2025 оны 12 р сарын 31-ээрх үлдэгдэл	110,547,900.00	16,428,492.00	(106,648,582.98)	19,568,028,504.47	10,337,185,574.62	26,552,526,028.14	56,445,210,932.25	3,609,170,016.00	60,054,380,948.25
Нягтлан бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө алдааны залруулга	-	-	-	-	-	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	110,547,900.00	16,428,492.00	(106,648,582.98)	19,568,028,504.47	10,337,185,574.62	26,552,526,028.14	56,445,210,932.25	3,609,170,016.00	60,054,380,948.25
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	-	-	-	6,182,657,099.69	6,182,657,099.69	-	6,182,657,099.69
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	26,902,443.27	-	26,902,443.27	32,856,984.00	59,759,427.27
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	250,000,000.00	250,000,000.00	-	250,000,000.00
2025 оны 12 р сарын 31-ээрх үлдэгдэл	110,547,900.00	16,428,492.00	(106,648,582.98)	19,568,028,504.47	10,364,088,017.89	32,485,183,127.83	62,404,770,475.21	3,642,027,000.00	66,046,797,475.21
Нягтлан бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө алдааны залруулга	-	(16,428,492.00)	152,611,232.88	-	6,758,327,886.21	7,466,395,134.40	(539,027,523.31)	-	(539,027,523.31)
Залруулсан үлдэгдэл	110,547,900.00	-	45,962,649.90	19,568,028,504.47	17,122,415,904.10	25,018,787,993.43	61,865,742,951.90	3,642,027,000.00	65,507,769,951.90
Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	-	-	-	-	-	4,761,249,113.85	4,761,249,113.85	-	4,761,249,113.85
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	11,281,514.00	-	11,281,514.00	-	11,281,514.00
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-	-	-	-
2025 оны 12 р сарын 31-ээрх үлдэгдэл	110,547,900.00	-	45,962,649.90	19,568,028,504.47	17,133,697,418.10	29,780,037,107.28	66,638,273,579.75	3,642,027,000.00	70,280,300,579.75



АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 31-ээрхи/

/төгрөгөөр/

Үзүүлэлт	12/31/2024	12/31/2025
Мөнгөн орлогын дүн	32,437,617,565.88	77,245,722,128.30
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	29,815,727,867.06	26,262,610,402.10
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	2,267,280,785.35	44,731,050,947.30
Бусад мөнгөн орлого	354,608,913.47	6,252,060,778.90
Мөнгөн зарлагын дүн (-)	23,747,545,609.11	31,364,027,950.80
Ажиллагсдад төлсөн	4,605,413,769.45	4,921,063,576.60
НДБайгууллагад төлсөн	1,417,183,519.06	1,206,926,902.20
Бараа материал худалдан авахад төлсөн	10,954,949,086.03	8,799,520,735.10
Ашиглалтын зардалд төлсөн	2,025,762,506.25	2,199,740,796.90
Түлш шатахуун тээврийн хэрэгсэлд төлсөн	730,021,646.79	231,193,559.10
Хүүний төлбөрт төлсөн	596,268,746.90	687,021,492.50
Татварын байгууллагад төлсөн	3,394,047,489.63	3,088,665,454.30
Даатгалын төлбөрт төлсөн	23,898,845.00	17,414,663.00
Бусад мөнгөн зарлага	-	10,212,480,771.10
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	8,690,071,956.77	45,881,694,177.50
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	1,344,738,199.65	3,598,504,387.30
Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого	5,970,500.00	26,200,000.00
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	230,000,000.00	-
Бусад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	874,256,068.56	3,238,058,737.40
Хүлээн авсан хүүний орлого	213,625,910.09	278,465,992.00
Хүлээн авсан ногдол ашиг	20,885,721.00	-
Бусад	-	55,779,657.90
Мөнгөн зарлагын дүн (-)	5,072,539,592.68	62,457,832,708.80
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,806,707,556.03	7,160,801,647.00
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	19,681,094.00	1,554,000,000.00
Бусад олгосон зээл болон урьдчилгаа	3,246,150,942.65	53,743,031,061.80
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(3,727,801,393.03)	(58,859,328,321.50)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	2,468,143,689.90	27,627,068,063.40
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	2,416,229,307.22	27,613,790,049.40
Бусад	51,914,382.68	13,278,014.00
Мөнгөн зарлагын дүн (-)	5,712,965,797.04	5,899,498,687.17
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	5,461,553,867.04	4,538,041,150.17
Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	1,110,457,537.00
Төлсөн ногдол ашиг	250,000,000.00	250,000,000.00
Бусад	1,411,930.00	1,000,000.00
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(3,244,822,107.14)	21,727,569,376.23



Валютын ханшийн зөрүү	3,189,911.20	
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,717,448,456.60	8,753,125,143.43
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,718,161,016.55	4,435,609,473.15
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,435,609,473.15	13,188,734,616.58



А. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хуулийн этгээдийн нэр: "Дархан нэхий" ХК
Хуулийн этгээдийн хариуцлагын хэлбэр: Хувьцаат компани
Улсын бүргэлийн дугаар: 1910010003
Регистрийн дугаар: 2649624
Албан ёсны хаяг: Дархан Уул аймаг, Дархан сум, 13-р баг, үйлд-вэрийн район, Өөрийн компанийн байр
Утас: 7037-8499
Харилцдаг санхүү, татварын байгууллага: Дархан Уул аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс, татварын хэлтэс

"Дархан нэхий" хувьцаат компани 1972 оноос үйл ажиллагаа явуулж байгаа туршлагатай, том үйлдвэрийн нэг. Байгальд ээлттэй, хэмнэлттэй эко технологиудын ололтыг нэвтрүүлсэн. Евро стандартад нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэл явуулдаг. Үйлдвэрлэлийн хүчин чадал Бодын шир боловсруулах үйлдвэр: Хоногт 1000 ширхэг буюу жилд 300000 ширхэг бодын арьс боловсруулж хөх шир, краст, гутал цүнхний гүйцээн боловсруулсан арьс, хуулдсан арьсууд үйлдвэрлэх, Богийн арьс боловсруулах үйлдвэр: Хоногт 5000 ширхэг буюу жилд 1,5 сая хонь ямааны арьс боловсруулж хувцасны үслэг нэхий, савхи үйлдвэрлэх, Жижиг арьс боловсруулах үйлдвэр: Жилдээ 200000 ширхэг хурга, ишиг, туулай болон ангийн арьс боловсруулж зах, дотор, шубны арьс үйлдвэрлэх, Оёдлын үйлдвэр: Жилд 0,5 сая ширхэг нэхий болон савхин хувцас бүтээгдэхүүн үйлдвэрлэх, Гутлын үйлдвэр: Жилд 0,5 сая хос өвөл, хавар намрын гутал үйлдвэрлэх хүчин чадалтай бөгөөд тухайн салбартаа хамгийн өндөр цалин хангамжтай 500 гаруй мэргэшсэн ажилтантай

Дархан нэхий Хувьцаат компанийн дүрэмд дараах үйл ажиллагааг эрхлэхээр заасан байна.

1. Нэхий, арьс боловсруулалт оёдол
2. Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа
3. Төрөлжсөн бус дэлгүүрийн бусад жижиглэнгийн худалдаа
4. Оёдол, гутал үйлдвэрлэл
5. Бизнесийн зөвлөх үйлчилгээ

Дэвшлийг хэрэгжүүлэгч, ёс зүйг эрхэмлэгч, байгальд ээлтэй компани уриатайгаар Дархан хотын нүүр царай болсон брэнд бүтээгдэхүүнүүдийг олон жил тогтмол үйлдвэрлэн ажиллаж байна.

Б. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ БЭЛТГЭЖ, ТАЙЛАГНАСАН ҮНДЭСЛЭЛ

Санхүүгийн тайлангийн зорилго.

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүтээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан нэхий ХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Дархан нэхий ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланг СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

НББ-ийн өрөнхий суурь:

Санхүүгийн тайлангууд нь Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандалтын Хороо (НББОУСХ)-оос баталсан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС) болон тус зөвлөлийн тайлангийн хорооноос гаргасан тайлбарын дагуу бэлтгэсэн байна.

Хэмжилтийн үндэслэл:

Санхүүгийн тайлангуудыг Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудын тайлагнах валют болох Монгол улсын мөнгөн тэмдэг төгрөг, мөнгөөр илэрхийлж, аккрузль сууриар бэлтгэн тайлагнасан.

Тасралтгүй үйл ажиллагааны зарчим:

Санхүүгийн тайланг байгууллагын тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх чадвартай эсэх үнэлгээг санхүүгийн тайлан гаргах хариуцлага хүлээсэн удирдлага хийх хэрэгтэй бөгөөд энэ зарчимд тулгуурлан бэлтгэсэн.

В. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД

Тус компани нь санхүүгийн тайлан бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн дараах үндсэн бодлогуудыг баримталдаг.

а) Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө:

Мөнгөн хөрөнгийн тайлан бэлтгэх зорилгоор мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь бэлэн мөнгө болон банк санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгөн хөрөнгө (барьцаалсан хадгаламжийг оруулахгүй)- өөс бүрдэнэ.

б) Санхүүгийн хэрэгсэл

1. Санхүүгийн хэрэгслийн анхны хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

СТОУС 9-д зааснаар санхүүгийн хэрэгслийг ашиг, алдагдлын дараах бодит үнэ цэнээр хэмжигдэх санхүүгийн хэрэгсэл, бусад дэлгэрэнгүй орлого болох бодит үнэ цэнээр хэмжигдэх санхүүгийн хэрэгсэл болон хорогдуулсан өртгөөр хэмжигдэх санхүүгийн хөрөнгө ба өр

төлбөр гэж ангилдаг. Бүх санхүүгийн хэрэгслийг анх бодит үнэ цэнээр нь хэмжиж, хүлээн зөвшөөрдөг. Компанийн санхүүгийн хөрөнгө нь мөнгө, худалдааны ба бусад авлага, борлуулахад бэлэн үнэт цаас болон бусад санхүүгийн хэрэгслийг агуулна. Компанийн санхүүгийн өр төлбөр нь худалдааны болон бусад өглөг, банкны овердрафт, зээл, санхүүгийн баталгаат гэрээ болон үүсмэл санхүүгийн хэрэгслийг агуулна.

2. Санхүүгийн хэрэгслийн дараа үеийн хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

Урт хугацаат санхүүгийн хэрэгсэлд тогтмол буюу тодорхойлогдох боломжтой төлбөр бүхий үүсмэл бус санхүүгийн хэрэгслүүд багтах бөгөөд анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш үе ашигт хүүгийн түвшний аргаар тооцсон хорогдуулсан өртгөөс үнийн бууралтыг хассан дүнгээр хэмжиж, хүлээн зөвшөөрдөг. Санхүүгийн хэрэгслийн хөнгөлөлт ба урамшууллыг тооцох замаар хорогдуулсан өртгийг үр ашигт хүүгийн аргаар тооцоолдог. Үр ашигт хүүгийн аргаар тооцоолсон урамшууллын хорогдуулалтыг орлогын тайланд санхүүгийн орлого ба зардлаар тайлагнадаг. Үнийн бууралтаас үүдэлтэй олз гарзыг орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг.

в) Гадаад валютаарх ажил гүйлгээ

Гадаад валютаарх мөнгөн хөрөнгийн үлдэгдэл болон гадаад валютаар илэрхийлэгдсэн авлага, өр төлбөрийн үлдэгдлийг тайлагнах валют (төгрөг) руу хөрвүүлэхдээ балансын өдрийн албан ханшаар, тайлант жилд гадаад валютаар хийгдсэн орлого, зарлагын ажил гүйлгээг гарсан өдрийн албан ханшаар тус тус хөрвүүлсэн. (Жич: Албан ханш гэдэг нь тухайн өдөр Монгол банкнаас зарласан хаалтын ханш болно.)

г) Өмч, барилга, тоног төхөөрөмж

1. Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

Өмч, барилга, тоног төхөөрөмжийг анх өртгөөр нь хүлээн зөвшөөрнө. Өмч, барилга, тоног төхөөрөмжийн өртөг нь худалдан авсан үнэ, импортын гатвар, эргэн төлөгдөхүй худалдан авалтын татвар болон тухайн хөрөнгийг зориулалтын ажлын байршил, нөхцөлд бэлэн болгохтой холбогдсон бусад зардал зэргээс бүрдэнэ.

Хэрэв тухайн хөрөнгийн гол эд ангийн ашиглах хутацаа ялгаатай байгаа тохиолдолд тэдгээрийг салгаж тусад нь ангилдаг.

Өмч, барилга, тоног төхөөрөмжийг борлуулснаас үүссэн олз ба гарзыг борлуулж буй үнэ болон тухайн хөрөнгийн даисны үнэтэй харьцуулж тодорхойлдог бөгөөд цэвэр дүнгээр орлогын тайланд "бусад олз/гарз" -аар хүлээн зөвшөөрдөг.

2. Дараа үеийн зардал

Өмч, барилга, тоног төхөөрөмжийн эд ангийг дахин солих, орлуулахтай холбоотой өртгийг уг эд анги ирээдүйд эдийн засгийн үр өгөөж өгөх болон өртгийг найдвартай хэмжих боломжтой үед хөрөнгөөр хүлээн зөвшөөрнө. Солигдсон эд ангийн дансны үнээр хөрөнгийн дансны үнийг бууруулна. Өдөр тутмын үйлчилгээний зардлыг тухайн зардалд гарсан тайлант үеийн орлогын тайланд зардлаар хүлээн зөвшөөрнө.

3. Элэгдэл

Элэгдлийг өмч, барилга, тоног төхөөрөмжийн ашиглагдах хугацаагаар нь шулуун шугамын аргаар байгуулж, орлогын дэлгэрэнгүй тайланд тусгана. Өмч, барилга, тоног төхөөрөмжүүдийг ашиглахаар тогтоосон хугацаа нь дараах байдалтай байна.

- | | |
|----------------------------------|--------|
| • Барилга байгууламж | 25 жил |
| • Тавилга, тоног төхөөрөмж | 10 жил |
| • Тоног төхөөрөмж | 10 жил |
| • Компьютерийн дагалдах хэрэгсэл | 2 жил |
| • Бусад хөрөнгө | 10 жил |

Элэгдүүлэлтийн арга, ашиглах хугацаа, үлдэх ертгийг тайлагнах үе бүрт дахин тооцож үзнэ.

4. Түрээслэсэн хөрөнгө

Тухайлсан хөрөнгийг зөвшөөрсөн хугацаанд ашиглах эрхийг тодорхой төлбөртэйгээр шилжүүлэх хэлцэл гэж компани нь тодорхойлж байгаа тохиолдолд ажил гүйлгээ буюу бүлэг ажил гүйлгээнээс бүрдэх хэлцлийг түрээс гэж үздэг. Ийм тодорхойлолтыг хэлцлийн шинж байдлыг үнэлсний үндсэн дээр хийдэг бөгөөд энэ хэлцэл нь түрээсийн хууль зүйн хэлбэртэй эсэхээс үл хамаарна.

Хөрөнгийн өмчлөлтэй холбоотой холбогдсон бүх эрсдэл болон урамшууллыг компанид бүрэн шилжүүлэх үед үүсэх санхүүгийн түрээсийг түрээслэсэн хөрөнгийн зах зээлийн бодит үнэ цэнээр эсвэл түрээсийн хамгийн бага төлбөрийн өнөөгийн үнэ цэнээр түрээс эхэлсэн үед нь хүлээн зөвшөөрдөг.

Түрээсийн төлбөрүүд нь санхүүгийн зардал ба түрээсийн өглөгийн бууралтад хуваагдах бөгөөд өглөгийн эцсийн үлдэгдэлд тогтмол хүү тооцдог. Санхүүгийн зардлыг орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрдөг. Түрээслэсэн хөрөнгийг нь хөрөнгийн ашиглалтын хугацааны турш элэгдүүлдэг.

Түрээсийн хугацааны эцэст эзэмшил нь компанид шилжиж ирэх нь тодорхойгүй үед хөрөнгийг ашиглалтын хугацаа болон түрээсийн хугацааны аль богино хугацаагаар элэгдүүлдэг.

е) Бараа материал

Бараа материалыг өртөг, цэвэр боломжит үнийн аль багаар нь тусгана. Бараа материалын өртгийг жигнэсэн дундаж өртгийн аргаар тодорхойлох бөгөөд худалдан авалт, боловсруулалт, байршуулалт зэрэг тухайн байршил, нөхцөлд авчрах хүртэлх зардлыг өртөгт шингээнэ.

Бараа материалыг өртөг, цэвэр боломжит үнийн аль багаар нь үнэлнэ. Цэвэр боломжит үнийг бизнесийн хэвийн нөхцөл дэх тооцоолсон борлуулах үнээс түүнийг иж бүрдэл болгоход тооцсон зардал болон борлуулалтын зардлыг хасч тооцно.

ё) Худалдааны болон бусад авлага

Бэлэн мөнгө хүлээн авах гэрээт эрх үүсэх буюу өөр нэг аж ахуйн нэгжээс санхүүгийн хөрөнгийг авах эрх үүссэн тохиолдолд худалдааны болои бусад авлагуудыг эхидээ өртгөөр нь бүртгэдэг. Дараа үеүдэд худалдааны болон бусад авлага нь найдваргүй авлагын нөөцийг хассан цэвэр боломжит үнэ цэнээрээ тусгагддаг.

ж) Худалдааны болон бусад өглөг

Худалдааны болон бусад өглөгийг өртгөөр нь хэмждэг. Бэлэн мөнгө өгөх гэрээт эрх үүсэх буюу өөр аж ахуйн нэгжид санхүүгийн хөрөнгийг хүргэх эрх үүссэн тохиолдолд өглөгийг хүлээн зөвшөөрнө.

з) Хувьцаат капитал

Энгийн хувьцаа: -г эзэмшигчдийн өмчид ангилдаг. Энгийн хувьцаа ба хувьцааны опционыг гаргахад шууд хувиардагдах нэмэгдэл өртгийг аливаа татварын нөлөөг хассан цэвэр дүнгээр нь өмчийг бууруулан хүлээн зөвшөөрнө.

и) Ногдол ашиг

Ногдол ашгийг зарласан гухайн тайлангийн хугацаанд нь өр төлбөр гэж хүлээн зөвшөөрнө.

й) Орлого хүлээн зөвшөөрөлт

1. Борлуулсан хөрөнгө

Борлуулсан үл хөдлөх хөрөнгө (ҮХХ)-өөс олсон орлогыг буцаалт, худалдааны болон тоо хэмжээний хөнгөлөлтийн дүнг хассан цэвэр дүнгээр хүлээн авсан эсвэл хүлээн авах бодит үнэ цэнээр хэмждэг. Дараах нөхцлүүд хангагдсан тохиолдолд борлуулалтын орлогыг хүлээн зөвшөөрдөг. Үүнд:

- Тухайн ҮХХ-ийн өмчлөлийн голлох эрсдэл болон өгөөжийг худалдан авагчид шилжүүлсэн
- Борлуулсан ҮХХ-ийн удирдлага болон хяналтын аль аль нь компанид үлдээгүй
- Хүлээн зөвшөөрөх орлогын хэмжээ нь хэмжиж болохоор байх
- Ажил гүйлгээний урсгал нь компанид эдийн засгийн өгөөж өгөх магадлалтай байх
- Ажил гүйлгээтэй холбоотой гарсан болон гарах өртөг, буцаалтын тооцооллыг найдвартай хэмжих боломжтой байх

2. Үзүүлсэн үйлчилгээ

Үйлчилгээ үзүүлсэн тухайн үед нь үйлчилгээний орлогыг хүлээн зөвшөөрдөг. Үйлчилгээг хэрэглэгчдэд үзүүлээгүй үед хүлээн авсан орлогыг хойшлуулсан орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

3. Түрээсийн орлого

Түрээсийн орлогыг түрээсийн хугацааны туршид шулуун шугамын аргаар хүлээн зөвшөөрч, бүртгэдэг.

к) Өртөг/Зардал хүлээн зөвшөөрөлт

Тайлант хугацаанд хувь нийлүүлэгчдэд хуваарилснаас бусад шалтгааны улмаас мөнгөний гадагш урсгал хэлбэрээр хөрөнгийг бууруулж, өр төлбөрийг ихэсгэдэг эдийн засгийн өгөөжийн бууралт гарах үед зардлыг хүлээн зөвшөөрдөг.

1. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг

Борлуулалтын өртгийг бараа материалыг борлуулах үед буюу бараа, бүтээгдэхүүний өмчлөлийн эрхийг бусдад шилжүүлж орлого олсон тухайн тайлант хугацаанд нь зардлаар хүлээн зөвшөөрдөг.

2. Борлуулалт ба ерөнхий үйл ажиллагааны зардал

Борлуулалт ба ерөнхий үйл ажиллагааны зардлыг мөнгөөр төлөгдсөнөөс нь үл хамаарч гарсан тухайн тайлант хугацаанд нь зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

л) Санхүүгийн орлого/зардал

Санхүүгийн орлогод хөрөнгө оруулалтад бодогдсон хүүгийн орлогыг хамааруулна. Хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн аргыг хэрэглэн орлого олсон тайлант үеийнх нь орлогын тайланд тусгана.

Санхүүгийн зардалд зээлийн хүүгийн зардал хамааруулна. Капиталжуулах шаардлагыг хангасан хөрөнгийн худалдан авалт, барилгын ажил эсвэл үйлдвэрлэлтэй шууд хамааралтай капиталжуулагдсан зээлийн өртгөөс бусад бүх зээлийн хүүгийн зардлыг үр ашигт хүүгийн аргыг хэрэглэн гарсан тайдант үеийнх нь орлогын тайланд тусгана.

м) Зээлийн өртөг

Барьж босгоход хугацаа шаардлагатай хөрөнгийн өртөгг багаж байгаа зээлийн өртгийг тухайн хөрөнгийг ашиглахад бэлтгэх юмуу борлуулах үйл явцад шаардагдах зардал, зээлийн өртөг нь бий болсон үеэс эхлэн капиталжуулдаг.

Бэлтгэл ажил шаардагдах хөрөнгийг худалдан авах, барих, үйлдвэрлэхтэй шууд холбоотой гарсан зээлийн зардлыг (зээлийн хүүг агуулсан) тухайн хөрөнгийн өртгийн нэг хэсэг болгон капиталжуулдаг. Харин энэхүү зээлийн өртгийн капиталжуулалтыг тухайн хөрөнгийг барьж босгох үйл явц зогссон юмуу бүрэн дууссан үед зогсоодог.

н) Ажиллагсдын тэтгэмж

1. Түр хугацааны ажиллагсдын тэтгэмж: Богино хугацаат ажиллагсдын тэтгэмж нь хөнгөлөлтгүй сууриар хэмжигддэг бөгөөд ажиллагсдын ажил гүйцэтгэсэн тайлант үед нь зардлаар бүртгэдэг. Хэрэв ажиллагсдын гүйцэтгэсэн ажлын үр дүнгээс үүдэн компани хуулийн дагуу бонус өгөх хариуцлага хүлээх болон бонусын дүнг үндэслэлтэй тооцоолох боломжтой үед тооцоолсон дүнгээр богино хугацаат бонусын өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө.
2. Нийгмийн болон эрүүл мэндийн даатгал: Монгол улсын хуулийн дагуу Монгол улсад үйл ажиллагаагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагууд нь иийгмийн болон эрүүл мэндийн даатгалыг зохих ёсоор төлөх ёстой бөгөөд уг зардлыг гарсан тухайн үед нь орлогын тайланд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

Г. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТОДРУУЛГА: (төгрөгөөр)**1. Мөнгөн хөрөнгө**

Мөнгөн хөрөнгийг нэрлэсэн үнээр нь бүртгэсэн. Тайлант онд мөнгөн хөрөнгийн дүн дараах байдалтай байна.

Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31
Касс (төгрөг)	5,524,184.83	5,524,184.83
Харилцах (төгрөг)	4,430,085,288.32	13,183,210,431.75
Дүн	4,435,609,473.15	13,188,734,616.58

2. Авлага

Тайлант оны авлага борлуулалтын авлага, ажилчдаас авах авлага, байгууллагаас авах авлагын үлдэгдэлээр тайлагнагдсан байна.

Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31
2.1 Дансны авлага	1,093,446,198.90	4,721,419,667.86
2.2 Татвар НДШ-ын авлага	79,813,037.95	319,583,104.30
2.3 Бусад авлага	619,371,758.89	1,070,671,101.00
2.4 Бусад санхүүгийн хөрөнгө	9,494,502,800.70	9,588,767,446.20
Дүн	11,287,133,796.44	15,700,441,319.36

Тайлант онд 4,413,307.5 мянган төгрөгөөр авлага өссөн нь дансны авлага 3,627,973.5 мянган төгрөгөөр нэмэгдэж, Татвар НДШ-ын авлага 239,770.1 мянган төгрөг, Бусад авлага 451,299.34 мянган төгрөг, Бусад санхүүгийн хөрөнгө 94,264.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Эдгээр авлагуудад хасагдуулга тооцоогүй найдваргүй нөөц байгууллаагүй байна.

3. Бараа материал

Бараа материал эргэлттэй уялдуулан жилийн эцсийн байдлаарх бараа материалын хувьд үнэ цэнийн бууралтгүй гэж үзсэн. Тайлант оны бараа материалаарх хөрөнгө дараах үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31
3.1 Бараа материал	15,802,696,257.06	14,293,825,771.04
3.2 Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө	5,355,775,056.00	-
Дүн	21,158,471,313.06	14,293,825,771.04

4. Урьдчилж гарсан зардал

Тайлант онд урьдчилж төлсөн түрээс болон бэлтгэн нийлүүлэгчид төлсөн урьдчилгааг доорхи үлдэгдлээр тайлагнагдсан байна.

Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31
4.1 Урьдчилж төлсөн зардал /тооцоо	3,801,909,897.71	4,272,213,826.70
Дүн	3,801,909,897.71	4,272,213,826.70

5. Үндсэн хөрөнгө

Тайланд онд 5,546,371.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогоор бүртгэж, 162,087.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг эрх бүхий албан тушаалтаны шийдвэрээр акталсан байна. Үндсэн хөрөнгөнд элэгдэл тооцохдоо "Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай" хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.-т "Албан татвар төлөгчийн нэг ба түүнээс дээш жилийн хугацаанд ашиглах хөрөнгөд элэгдэл, хорогдлыг дараах байдлаар тооцно" гэсний дагуу элэгдэл хорогдлыг шулуун шугамын аргаар тооцож элэгдэл байгуулсан байна.

Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31
5.1 Барилга, байгууламж	25,175,775,531.12	25,305,545,111.72
5.2 Машин, тоног төхөөрөмж	3,372,762,583.25	6,784,358,497.72
5.3 Тээврийн хэрэгсэл	204,942,008.79	187,154,669.94
5.4 Тавилга, эд хогшил	733,616,453.51	657,896,213.24
5.5 Компьютер бусад хэрэгсэл	94,732,452.86	61,544,712.36
5.6 Газрын сайжруулалт	852,607,587.21	1,130,920,175.97
5.7 Бусад үндсэн хөрөнгө	73,610,364.81	202,020,957.62
5.8 Биет бус хөрөнгө	239,363,463.90	112,684,391.83
5.9 Дуусаагүй барилга	4,007,919,108.07	4,417,707,541.40
Дүн	34,755,329,553.52	38,859,832,271.80

6. Урт хугацаат хөрөнгө оруулалт

Тайлант онд 8,697,945.0 мянган төгрөгийн урт хугацаат хөрөнгө оруулалтыг бүртгэж тайлагнагдсан байна.

Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31
6.1 Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	8,697,944,999.08
Дүн	-	8,697,944,999.08

7. Өр төлбөр

Өр төлбөрийг барагдуулах дүнгээр нь тайлагнасан бөгөөд тайлант оны үлдэгдэл өмнөх оноос өссөн байна.

Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31
7.1 Дансны өглөг	1,009,055,672.39	1,464,550,919.90
7.2 Цалингын өглөг	500,837.99	1,527,549.30
7.3 Татварын өглөг	5,687,664,877.58	5,621,493,935.63
7.4 НДШ-ийн өглөг	9,703,020.67	69,382,041.40
7.5 Банкны богино хугацаат зээл	275,637,676.00	2,224,908,024.00
7.6 Урьдчилж орсон орлого	857,004,127.09	1,269,157,779.48
7.7 Бусад богино хугацаат өр төлбөр	-	-
Дүн	7,839,566,211.72	10,651,020,249.71

8. Урт хугацаат өр төлбөр

Өр төлбөрийг барагдуулах дүнгээр нь тайлагнасан бөгөөд тайлант онд 14,064,684.4 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын зээл үлдэгдэл байна.

Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31
8.1 Урт хугацаат зээл	1,370,521,245.00	14,064,684,383.50
8.2 Нөөц /өр төлбөр/	44,025,059.49	16,987,591.60
8.3 Хойшлогдсон татварын өр	137,544,042.46	-
Дүн	1,552,090,346.95	14,081,671,975.10

9. Өмч

Компанийн өмч нь дараах хэсгээс бүрдэнэ. Хувь нийлүүлсэн хөрөнгөнд өөрчлөлт ороогүй. Өмчийн дүн тайлант үеийн үр дүнгээр өссөн байна.

Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31
9.1 Хувийн өмч	110,547,900.00	110,547,900.00
9.2 Халаасны хувьцаа	16,428,492.00	-
9.3 Нэмж төлөгдсөн капитал	(106,648,582.98)	45,962,649.90
9.4 Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	19,568,028,504.47	19,568,028,504.47
9.5 Эздийн өмчийн бусад хэсэг	10,364,088,017.89	17,133,697,418.10
9.6 Хуримтлагдсан ашиг	32,485,183,127.83	29,780,037,107.28
9.7 Хяналтын эрхгүй хувь оролцоонд ногдох	3,642,027,000.00	3,642,027,000.00
Дүн	66,079,654,459.21	70,280,300,579.75

10. Орлого

Тус компанийн орлого нь нэхийний үйлдвэрлэл болон бусад үйлчилгээний орлогоос бүрддэг. Энэ оны орлого өмнөх оноос 4,480,304.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31
Борлуулалтын орлого/цэвэр/	16,542,923,483.95	18,467,919,520.70
Түрээсийн орлого	2,028,838,406.22	2,561,819,065.80
Хүүгийн орлого	1,303,338,744.64	3,979,302,501.90
Ногдол ашгийн орлого	49,450,888.05	40,055,006.60
Бусад орлого	9,832,806,234.78	48,100,100.20
Бусад ашиг (алдагдал)	5,563,557.31	185,421,049.30
Дүн	29,762,921,314.95	25,282,617,244.50

11. Зардал:

Цалин хөлс, НДШ, татвар хураамж, үлдсэн хөрөнгийн элэгдлээс бусад зардлын ажил гүйлгээ болон тагвар ногдох орлогоос хасагдахгүй алданги торгууль, хандив болон бусад хасагдахгүй зардлуудыг зөрүүгийн тайлангаар тайлагнасан байна.

Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	13,918,143,437.20	10,509,501,432.90
Борлуулалт. Маркетингийн зардал	6,189,707,630.22	5,342,791,087.13
Ерөнхий ба удирдлагын зардал	1,297,693,491.02	3,090,109,509.51
Санхүүгийн зардал	420,481,440.86	820,673,30.90
Бусад зардал	1,026,404,568.94	147,471,181.81
Дүн	22,852,430,568.24	19,910,546,842.25

12. Эрсдэлийн удирдлага

Компанийн бизнесийн хэвийн үйл ажиллагаа явуулах чадварт нөлөөлөхүйц ноцтой алдаа зөрчил, нэхэмжлэл, зарга, маргаан гэрээт ажлын явцад бидэнд ажиглагдаагүй болно.



“ЦЭСБ АУДИТ” ХХК
Нягтлан бодох бүртгэл хяналтын
итгэмжлэгдсэн хөндлөнгийн байгууллага

Хаяг: Дархан-Уул аймаг, Дархан сум, 10-р баг, 5-р
хороо, 380 айл, 2 давхар 65, 66 тоот
Утас: 9511-2689, 8927-5858

УДИРДЛАГАД ХҮРГЭХ ЗАХИДАЛ

“ДАРХАН НЭХИЙ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

Бид захиалагчтай байгуулсан гэрээний дагуу тус компанийн 2025 оны санхүүгийн тайланд аудитын үйлчилгээ үзүүлээ.

Аудитыг Аудитын Олон Улсын стандарт болон Монгол улсын “Аудитын тухай хуулийн дагуу мэргэжлийн ёс зүйг баримтлан хараат бусаар гүйцэтгэж, Сангийн сайдын 2017 оны 361 тоот тушаалын 01 дүгээр хавсралтаар “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар” ба 02 дугаар хавсралтаар “Санхүүгийн тайлангийн А маягт”-ын дагуух шаардлагыг ханган ажилласан болно.

Бид үйлчлүүлэгчийн жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үзүүлэлтүүдийн уялдаа холбоог нягталж, бидэнд ирүүлсэн тайлан, бусад хууль эрх зүйн баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийж, гадаад мэдээлэл хэрэгдэгчдэд хараат бус аудиторын дүгнэлт тодруулга бүхий аудитлагдсан тайлангуудыг бэлтгэж хүргүүлэхийн сацуу үйлчлүүлэгч байгууллагын дотоод удирдлага болон санхүүгийн ажилтанд зориулж санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг хууль журмын дагуу бодит байдалд нийцүүлэн засаж залруулах талаарх санал зөвлөмжөө Аудиторын зөвлөмж гэсэн хэсэгт илэрхийллээ.

Тайлант үеийн үр дүн

Компани нь 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт хөрөнгийн өөрчлөлт 19,574,538.77 мянган төгрөгөөр нэмэгдсэн ба 4,761,249.1 мянган төгрөгийн ашигтай ажилласныг санхүүгийн тайландаа тусгаж баталгаажуулсан байна.

Аудиторын зөвлөмж:

Ажиглалт

Үйлчлүүлэгчийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаа дараах байдалтай байна. Үүнд:

- Нийгмийн даатгал, аж ахуй нэгжийн орлогын албан татварын хуримтлагдсан өр төлбөр байна.

Нөлөөлөл:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын болон Татварын тухай багц хуулиуд заасаны дагуу хүү, алданги торгуулийн эрсдэлд орох, компанийн ажиллагсадын эрх зөрчигдөх,
- Компанийн тухай хууль болон компанийн дүрмийн холбогдох заалт зөрчигдөх;

Зөвлөмж:

- Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Компанийн тухай хуулийн 6.6.-д "Толгой компанийн гаргасан шийдвэрийн улмаас охин компани төлбөрийн чадваргүй болсон бол толгой компани нь тухайн өрийг хамтран хариуцна." 9.5.-д "Хувьцаа эзэмшигчийн компанид оруулсан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх нь хувийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээс тодорхой зааглагдаагүй бол уг хувьцаа эзэмшигч өөрийн бүх эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээр компанийн өр төлбөрийг давхар хариуцна." тус тус заасан тул хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах шаардлагатай.

Бид энэ удаагийн аудитаараа компанийн санхүүгийн тайлангийн уялдаа холбоог нягтлах, хууль журмын хэрэгжилтийн талаарх ерөнхий зөвлөмжөө хүргүүллээ

Шийдвэрлэгдээгүй бөгөөд дараагийн аудитаар судлах асүүдал:

Санхүүгийн байдлын тайлангаарх эздийн өмчийн бусад хэсэг дэх 17,133,697.5 мянган төгрөгийн үлдэгдлийг өмнөх он руу хоон Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын хавсралт "Аж ахуй нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын эздийн өмчийн бусад хэсэгт "Энэ хэсэгт бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрч өмчийн хэсэгт хуримтлуулан бүртгэсэн бусад олз, гарзын [\[13\]](#) дүнг толилуулна." гэсний дагуу тодруулах шаардлагатай байна

Цаашид бидэнд илүү их олон мэдээллээр хангаж санхүүгийн тайланг иж бүрэн боловсронгуй болгож хууль журмыг хэрэгжүүлэн ажиллах тал дээр хамтран ажиллана гэж найдаж байна. Дараагийн тайлант хугацаанд бидний өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана уу.

ХҮНДЭТГЭСЭН:

ЗАХИРАЛ АУДИТОР, МНБ  /М.ЦЭРЭННАДМИД/

АУДИТОР, МНБ  /М.МӨНХБАЯР/

